2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 16 цагт Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д боллоо.

Хурлын Тооллогын комиссоос Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг үндэслэн Техник импорт ХК-ийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн №155 тоот албан бичгийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон ирүүлсэн Техник импорт ХК-ийн “Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй болон дэлгэрэнгүй судалгаа”-гаар бүртгэлийн ажиллагааг явуулахад 1 446 755 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 461 хувьцаа эзэмшигчээс 492 894 ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр, 936 640 хувьцаа эзэмшдэг 7 хувьцаа эзэмшигч биечлэн оролцохоор нийтдээ 1 429 534 хувьцаа эзэмшдэг 9 хувьцаа эзэмшигч бүртгүүлэв.

Тооллогын комиссын бүртгэлийн ажиллагаа 16 цаг 10 минутанд дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн “Хурлын бүртгэлийн ажиллагаагаар тус хуралд 1 429 534 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувьцаа эзэмшигч оролцохоор бүртгүүлсэн нь компанийн 1 446 755 ширхэг энгийн хувьцааны 98,8 хувийг бүрдүүлж Компанийн тухай хуулийн 69.2 дахь заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.26 дахь заалтыг тус тус хангасан тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ирцийн мэдээллийг Хурлын даргад илтгэв.

Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа хурал зохион байгуулах комиссоос хурлын дэгийн талаарх танилцуулга, хэлэлцэх асуудалтай холбогдох материал, саналын хуудсуудыг хувьцаа эзэмшигчдэд тарааж өгөв.

Хурлын дарга Тооллогын комиссын дүнг үндэслэн хурлыг нээх, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг батлах эсэх талаар хувьцаа эзэмшигчдээс санал хураахад хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид санал нэгтэй “зөвшөөрснөөр” хурлын ажиллагаа эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Техник импорт ХК-ийн ТУЗ-ын Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Ж.Баярсайхан, Цалин, урамшууллын хорооны дарга, хараат бус гишүүн Б.Батсайхан, ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий, ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам нар оролцов.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, уг хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дарга, тооллогын комиссыг томилсон талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолыг Хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Д.Ганцэцэг даргалан удирдаж явуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан:

Хурлын дарга дараах асуудлуудыг компанийн Хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан тайлан, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, дэлгэц дээр харуулсан тоон мэдээллүүдэд үндэслэж тодруулж тайлбарлаж танилцуулав. Үүнд:

1. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан
3. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
4. 2024 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүнийг сонгох

ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын дэгийн дагуу дараах асуудлуудтай холбогдох тайлангуудыг Хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав. Үүнд:

1. 2022 оны ногдол ашгийн тайлан /Уншиж танилцуулсан тайланг хавсаргав/
2. 2023 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТУЗ-ын төсөв /Тайланг хавсаргав/

ТУЗ-ын нарийн бичгийн дарга: Та бүхэн тайлангаас асууж тодруулах зүйл байна уу?

Г.Гансүх: 2023 онд сонгогдсон ТУЗ-ын гишүүдээс энэ онд хэдэн гишүүн сонгогдож байгаа вэ? Шинээр сонгогдож байгаа гишүүн байгаа юу?

ТУЗ-ын нарийн бичгийн дарга: ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос 2023 оны ТУЗ-ын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт өгч дүгнэлт гаргасан. Нэр дэвшүүлэх хорооноос 2023 онд ТУЗ-ын гишүүнээр ажилласан 9 хүнийг хангалттай сайн ажилласан гэж дүгнэж бүрэлдэхүүнээр нь 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ын гишүүнээр нэрийг нь дэвшүүлэхээр дүгнэлт гаргасан. Та бүхний харж байгаа дэлгэцэн дээр танилцуулж байгаа 9 хүн 2023 онд ТУЗ-ын гишүүнээр ажилласан хүмүүс байна. Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ын гишүүнээр улиран сонгогдох давтамжид хязгаарлалт тавигдахгүй гэсэн заалт байдаг. Сүүлийн жилүүдэд гишүүдийн мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлэх, сайжруулахад Төлөөлөн удирдах зөвлөлөөс байнга анхаарч ажиллаж байгаа. 2023 онд ТУЗ-ын гишүүдийг батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтанд хамруулсан. 2023 оны сургалтанд нийт 72 000 000 төгрөгийг зарцуулсан. 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөл хариуцсан чиг үүргийнхээ дагуу болон компанийн үйл ажиллагаатай холбогдуулан 6 удаа асуудал хэлэлцэж шийдвэр гаргасан. 2023 онд ТУЗ-ын гишүүдэд 8 400 000 төгрөгийн цалин олгосон. Компанийн үйл ажиллагаа бүх талаараа жилээс жилд сайжирч байгаа нь компанийн удирдлагаас ирүүлж байгаа холбогдох ажлын тайлангууд, ТУЗ-ын Хороодын дүгнэлт болон ТУЗ-аас гаргаж байгаа хэлэлцсэн асуудлын шийдвэрүүдээс харагддаг. 2023 онд Компанийн тухай хууль болон СЗХ, Хөрөнгийн биржийн холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь компанийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээллийг хүргүүлж ажилласан. 2023 онд СЗХ-ноос анх удаагаа “Компанийн засаглалын хэрэгжилтийн кодекс”-ийг дүгнэх ажлыг Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт Хувьцаат компаниудын хэмжээнд хийсэн. Энэ ажлын дагуу компанийн холбогдох тайлан, нотлох баримтыг хүргүүлж ажилласан.

Хорооны анхны үнэлгээгээр компани Топ-10 компанийн 8-т орсон. Жилийн эцсийн үнэлгээгээр эхний Топ-20 компанийн ард буюу 21-р байранд орж үнэлэгдсэн байсан.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дууссаны дараа хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултанд дараах нэмэлт тайлбар, мэдээллийг Хувьцаа эзэмшигчдэд өгч Хувьцаа эзэмшигчидтэй харилцан мэдээлэл солилцлоо.

С.Мягмарсүрэн: Өнгөрсөн онд борлуулалт хэр байв?

Хурлын дарга: Урьд оноос борлуулалт 4 тэрбумаар буурсан. Дансны өглөг 8 тэрбумаар нэмэгдсэн. ТУЗ-аас эргэлтийн хөрөнгөөр өр авлагаа төлөх бүрэн боломжтой гэж дүгнэсэн. Өмнөх оны зарим борлуулалт энэ оны 1 сар луу шилжсэн. Энэ байдлыг санхүүгийн саатлаас болсон гэж ойлгож болно. Энэ жилээс улирал тутам авлага, борлуулалтын тайланг гаргаж тайлагнахыг ТУЗ-аас үүрэг болгосон. /2023 оны борлуулалтын дүнг дэлгэц дээр харуулав/ Битумын борлуулалтыг 2022 онтой харьцуулахад 2023 онд битумын борлуулалт 15 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ онд битумын борлуулалт хүлээсэн хүлээлтэнд хүрээгүй. 2023 онд эдийн засгийн байдлаас шалтгаалаад борлуулалт буурсан. Цементийн борлуулалтыг компаниудтай урамшууллын гэрээ байгуулж борлуулдаг. Энэ жилийн хувьд цементийн борлуулалт 50%”д хүрсэн.ТУЗ-аас санхүүгийн тайланд хийх аудитыг “Лидер экаунт” ХХК-иар хийлгэж байгаа. Аудитаас бүх гүйлгээ рүү орж шалгах болж байна. Татварын байгууллага л тэгж шалгадаг байсан. Аудитын компани ёс зүйтэй байх нь чухал л даа. Компанийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх үүднээс хийгээсэй гэж бодож байна. Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг та бүхнийг харсан гэж бодож байна. 2023 онд мөн хамтарсан компани болох Күботад showroom хийсэн. Трактор, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнг 4 сарын эхээр япон талтай хамтран зохион байгуулж явуулсан.

ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий: 2023 оны компанийн онцлох ажлыг дурдвал компанийн 65 жилийн ой 12 сард болсон. Компанийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO-9001:2015-ийг стандартын дагуу нэвтрүүлж гэрчилгээгээ авсан. Оны сүүлчээр компанийн захирал маань “Худалдааны гавьяат ажилтан” цол тэмдгээр шагнагдсан.

Хурлын дарга: 2023 онд охин компанид нэлээн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Ж.Энхтунгалаг: Танайх хамтарсан компани байгуулсан гэсэн. Ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

Хурлын дарга: Хөдөө аж ахуйн трактор, тоног төхөөрөмж худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Япон тал маань нэлээн дэмжлэг үзүүлж ажилладаг. Хамтарсан компанид монгол талаас 10-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Манай компанийн хувьцааны үнэлгээ бирж дээр өнөөдрийн байдлаар ямар үнэлгээтэй байна вэ? Та нар харсан уу?

Г.Гансүх: 40 орчим мянга байсан.

Хурлын дарга: Манай нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг. Тэгэхээр нийт гаргасан хувьцааныхаа тоогоор 1 446 755 төгрөгийн үнэтэй компани гэж байхгүй л дээ. Бодит байдал дээр хөрөнгийн үнэлгээ нь өөр байгаад байдаг. Бирж дээр арилжаалагдаж байгаа 39 000 төгрөгийн зөрүүний асуудлыг яаж шийдвэрлэх вэ. Ямар нэгэн татварын дарамтгүйгээр хөрөнгийн үнэлгээ хийхэд анхаарч ажиллая гэж энэ жил бодож байгаа. 2018 онд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн. Тэрийгээ балансад тусгаагүй. Актив болон дансны өглөг өндөр байгаа.

Г.Гансүх: Танайх нийт хэдэн ажилтантай вэ?

Хурлын дарга: 75 ажилтантай.

Г.Гансүх: Ажлын ачаалал их л юм байна.

С.Мягмарсүрэн: Гадны хөрөнгө оруулалттай хамтарсан компани 2 байгаа гэсэн. Хэдэн хувийг танайх эзэмшдэг юм бэ?

Японы хөрөнгө оруулалттай 2 компанийг байгуулсан. Нэг нь будаа үйлдвэр, нөгөөх нь хөдөө аж ахуйн трактор, тоног төхөөрөмж борлуулдаг компани байгаа. Будааны үйлдвэрийг 50:50 гэсэн харьцаагаар япон талтай эзэмшдэг. Күбота компанийг 51:49 гэсэн харьцаагаар буюу япон тал 51%, манайх 49%-иар эзэмшдэг. 5 жилийн дараа үр ашгаа өгөхөөр төлөвлөж тооцоолж ажиллаж байна.

С.Мягмарсүрэн: Дотоодын хамтарсан компанид танай компани хэдэн хувийг эзэлдэг вэ?

Хурлын дарга: Хантеч ХХК-ийг 49:50 харьцаатайгаар эзэмшдэг. Энэ компани маань цемент ачиж буулгах тээврийн үйлчилгээ эрхэлдэг компани. Эм Жи Эл Цемент ХХК цементийн түүхий эдийг боловсруулж цемент үйлдвэрлэдэг компани. Өнгөрсөн жилд түүхий эдийн хомсдолоос шалтгаалж бараг үйл ажиллагаа явуулаагүй. Монгол иргэнтэй хамтран хувьцаа эзэмшдэг. Энэ онд компани зуун хувь эзэмших төлөвлөгөөтэй байгаа.

С.Мягмарсүрэн: Авлагын дүн өндөр байна?

Хурлын дарга: Авлага гэдэг дээр орон сууц байгаа. Эхнээсээ төлөгдөөд эхэлсэн. 20-оод тэрбум төгрөгийн хөрөнгийн авлага байгаа. Орон сууц борлогдсон тохиолдолд авлага буураад явж байгаа. Өөрөөр хэлбэл авлагыг маань хөрөнгөөр баталгаажсан авлага гэж хэлж болно.

Ж.Энхтунгалаг: Тэр орон сууцнууд чинь хаана байгаа вэ?

Хурлын дарга: Та манай компанийн менежерүүдтэй уулзаад байрны жагсаалттай танилцаад газар дээр нь очоод сонирхож байгаа байраа үзэж болно. Байр худалдан авах тохиолдолд манайхаас материалыг судлаад ХХБ-д өгнө. Манай компани ХХБ-тай хамтран ажилладаг.

Ж.Энхтунгалаг: Байрнууд их үнэтэй байна. Хямдханууд нь хотын захаар л байх юм. Байрны үнэ чинь доод тал нь 3 сая гарчихаад байна. Хэцүү л байх юм.

С.Мягмарсүрэн: Хөрөнгийн үнэлгээг та сая яаж хийлгэнэ гэж хэлсэн билээ?

Хурлын дарга: Татварын дарамтгүйгээр үнэлгээ хийлгэнэ гэж хэлсэн. 2007 оноос өмнө газар дээр татвар байхгүй байсан. Одоо бүх зүйлээ үнэлчихээр газар дээр татвар ногдохоор болчихоод байна. Манай компани одоогийн байдлаар газар эзэмших эрхийн дагуу жилдээ 70 сая төгрөгийг газрын татварт төлж байгаа. Газраа үнэлгээнд оруулчихвал татвар төлөгдөхөөр болчихоод байна. Хөрөнгө талдаа газраа бүртгэвэл татвар авахаар болчихно. 2024 онд борлуулалтын ашгаа нэлээн нэмж төлөвлөсөн. Борлуулалтын тайлан үргэлж алдагдалтай гардаг байсан бол энэ жилийн хувьд авлагатай гарсан. 2024 онд 251 тэрбум 400 сая гаран төгрөгийн борлуулалт хийнэ гэж төлөвлөсөн.

С.Мягмарсүрэн: Танай компани цемент, битум, арматур, мотоцикл борлуулдаг.Тус бүрээс нь хэдэн хувийн борлуулалт хийдэг вэ?

Хурлын дарга: 40%-ийг цемент, 30%-ийг битум, 10%-ийг арматур, 30%-ийг мотоцикл эзэлдэг.

С.Мягмарсүрэн: Энэ жил эдийн засгийн байдал сайн байна гэж үзэж байна уу?

Хурлын дарга: Энэ жил сайнгүй байна. Жил бүр 2 сараас ажил эхэлдэг байсан. Энэ жилийн хувьд одооноос л эхэлж байна. Энэ жил нэлээн эрч хүчтэй ажлаа эхэлж байгаа.

Б.Ганболд: Таны энэ жилийн ажилд амжилт хүсье.

Хурлын дарга: Баярлалаа. Та бүхний ажилд бас ажлын өндөр амжилт хүсье. Хурлаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс өөр асуух, нэмж тодруулах зүйл байна уу? Байхгүй байна. Санал хураалт явуулахыг зөвшөөрч байна уу?

8 хувьцаа эзэмшигч санал нэгтэй зөвшөөрч гараа өргөв.

Хурлын дарга: Хурлаар хэлэлцсэн асуудлын талаар хурлаас гарах тогтоолын төсөлд саналын хуудсаар санал хураалт явуулья. Тооллогын комисст саналын хуудсаар санал авч дүнг нэгтгэн танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн: Тооллогын комисст компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% буюу 1 429 534 ширхэг хувьцаа эзэмшигчийн саналын хуудас ирсэн. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар хэлэлцэх асуудалд саналаа өгсөн байна. Нийт тоологдсон саналын хуудас 9 байна. Үүнээс хүчинтэй саналын хуудас 9, хүчингүй саналын хуудас байхгүй байна. ТУЗ-ын гишүүдийг сонгох саналыг кумулятив аргаар дүгнэж гаргасан. Хурлаар хэлэлцсэн бусад 4 асуудлыг нэг бүрчлэн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” хэлбэрээр санал авч саналын хуудсуудын дүнг нэгтгэж гаргасан. Саналын хуудсуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд хуралд оролцогч нийт 9 хувьцаа эзэмшигч хурлаар хэлэлцсэн 5 асуудлыг бүгд 100%-ийн саналаар дэмжиж зөвшөөрсөн учир хурлын саналын хуудсуудыг үндэслэн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах Тооллогын комиссын тогтоолын төслүүдийг батлуулах шийдвэрийг гаргаж байна.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудыг Хувьцаа эзэмшигч та бүхэн зуун хувь зөвшөөрч дэмжсэн тул 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг батлах шийдвэрийг гаргаж байна. Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилтыг хүсье. Хурал өндөрлөснийг мэдэгдэж байна.

Хурал 18 цаг 02 мин дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ын нарийн бичгийн дарга: О.Бүжинлхам

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ДАРГА: Д.ГАНЦЭЦЭГ